



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар A/175

Улаанбаатар хот

**“Нүүдэлчин Монгол 2025” Соёлын
биет бус өвийн их наадам арга хэмжээнд
оролцох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 41 дүгээр тогтоол, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны A/211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт 2025 оны 08 дугаар сарын 22, 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж буй “Нүүдэлчин Монгол 2025” Соёлын биет бус өвийн их наадамд бичил бизнес, үйлдвэр эрхлэгчдийг соёлын бүтээлээр үзэсгэлэнд хамруулахыг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв (Д.Ууганбаатар)-д үүрэг болгосугай.

2. “Нүүдэлчин Монгол 2025” Соёлын биет бус өвийн их наадам арга хэмжээнд оролцох бичил бизнес, үйлдвэр эрхлэгчдийн нэрсийг нэгдүгээр, зарцуулагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 1,864,150 (нэг сая найман зуун жаран дөрвөн мянга нэг зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 21-ны өдрийн АРК дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



“Нүүдэлчин Монгол 2025” Соёлын биет бус өвийн их наадам арга
хэмжээнд хамрагдах бичил, бизнес эрхлэгчдийн нэрс

№	Овог нэр	Үйл ажиллагааны чиглэл	Харилцах утас
3	Б.Мөнхжаргал	Монгол дээл, хувцас, загварын дээл	99596408, 80031158
4	Ч.Мэндэл	Арьсан эдлэл	99143217
5	Б.Саранчулуун	Модон эдлэл	99182005

ийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 27-ны өдрийн 818 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



“Нүүдэлчин Монгол 2025” Соёлын биет бус өвийн
их наадам арга хэмжээнд зарцуулагдах төсөв

№	Бараа материалын нэр	Тоо ширхэг (1өдөрт)	Хэмжих нэгж	Нийт хоног	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Асар түрээс	1	ш	3	510,000	1,530,000
2	Хог хураамж	-	тн	3	30,000	90,000
3	Бензин	-	л	3	2,570	244,150
	Нийт дүн					1,864,150